



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах түр штаб
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.3.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/732 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэл, Газрын дүрмийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах, үерийн хор уршгийг арилгах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах “Гамшгаас хамгаалах түр штабын бүрэлдэхүүн”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэл болон 2023 оны “Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” А/31 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд бусад албан хаагчдыг дайчлан оролцуулж, удирдлагыг цаг үеийн мэдээллээр хангаж ажиллахыг Гамшгаас хамгаалах түр штаб (Б.Найрамдал)-д, дээрх хугацаанд шуурхай бэлэн байдлыг хангуулахыг нийт албан хаагчдад тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА  СТӨМӨРДУЛАМ

